

# “УЛААНСАН” ХК

2025 оны 02 сарын 10

№25/01

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Ногдол ашиг хуваарилахгүй тухай*

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, Улаансан ХК (“Компани”)-ийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн “Улаансан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Компани нь 2024 оны санхүүгийн жилд үйл ажиллагаа явуулаагүй тул Компанийн санхүүгийн нөхцөл байдлыг харгалзан 2025 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай тогтоол, мэдэгдлийг Компанийн хувьцаа эзэмшигчид, олон нийт, эрх бүхий байгууллагад мэдэгдэх ажлыг зохион байгуулж ажиллахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ч.ТАНХУЯГ

# “УЛААНСАН” ХК

2025 оны 02 сарын 10

№25/02

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Толоолон удирдах зөвлөлийн  
дэргэдэх хороод байгуулах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, 81 дүгээр зүйлийн 81.1, 81.2 дахь хэсэг, Улаансан ХК-ийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.15 дахь хэсгийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасан дараах хороодыг байгуулж, гишүүдийг томилсугай:

1.1. Аудитын хороо:

1.1.1. Ч.Даваасамбуу

1.1.2. Х.Билгүүн

1.1.3. Г.Зол-Эрдэнэ

1.2. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо

1.2.1. Ч.Ганхуяг

1.2.2. С.Нямгэрэл

1.2.3. А.Азбаяр

1.3. Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо

1.3.1. Б.Золбоо

1.3.2. Г.Уянга

1.3.3. Ц.Батбаяр

2. Хороодын үйл ажиллагааг Компанийн дүрэм, журам, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлж ажиллахыг ТУЗ-ийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ч.ГАНХУЯГ